## НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
## АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр — Улаанбаатар хот

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| **ШҮГЭЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх | Баримтжуулсан байх<br>Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | Жилдээ | - | Авлигатай тэмцэх газраас “Авлигын эсрэг нэгдье” аяныг 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай аян зохион байгуулсан бөгөөд энэхүү аянд манай байгууллага нэгдэн нийслэлийн нутгийн захиргааны 1,200 байгууллагын 29,000 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаагаа цахимаар явуулдаг Дотоод удирдлагын UBERP системийн үйл явдал хэсэгт нэлттэй байршуулсан. Байгууллагын цахим хуудас https://it.ulaanbaatar.mn/ болон байгууллагын facebook хуудсаараа дамжуулан авлигын эсрэг аянд нэгдье аяны хүрээнд гаргасан видео шторк болон зурагт хуудсуудыг иргэд олон нийтэд нээлттэй байршуулах ажлыг зохион байгуулсан. Мөн “Мэдье, нэгдье” аяны хүрээнд Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах зорилгоор байгууллагын https://it.ulaanbaatar.mn/ цахим сайтад 1 сарын туршид 14 удаа АТГ-аас гаргасан шторк, зурагт хуудас, сонины | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргийг байршуулж нийт давхацсан тоогоор 196 үзэлт, хандалтыг аваад байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах | 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх<br>Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | 10.000,0 | Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг байгууллагынхаа https://it.ulaanbaatar.mn/, цахим хуудас, facebook хуудас мөн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд нийслэлийн 1200 байгууллагын 29,000 албан хаагч бүртгэлтэй Дотоод удирдлагын UBERP системээр дамжуулан зохион байгуулж<br><br><br>ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  | |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | Мэдээллийг сар бүр шинэчлэх Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг | Сар бүр | - | Байгууллагын иргэдэд зориулсан мэдээллийн самбар болон цахим хуудастаа Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс хөгжил, дэвшилд 110” мэдээллийг байрлуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хавсаргасан байх. | | | <br><br> | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | Сурталчилгаан ы материал боловсруулсан байх<br>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгаан ы самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх<br>Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | Жилдээ | - | Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг ашиглан, боловсрол, эрүүл мэнд, тээвэр, төрийн үйлчилгээ гэх мэт томоохон салбаруудын үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр хийгдсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнгийн талаарх мэдээ мэдээллүүдийг Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын ICT 2023 Expo, UB forum арга хэмжээ болон олон нийтийн сошиал суваг, facebook хуудсаараа дамжуулан хүргэж ажилласан.<br>“Мэдье, нэгдье” аяны хүрээнд Газрын даргын 2023 оны А/75 дугаар тушаалаар загвар баталж, байгууллагын нийт 21 ажилтан, албан хаагчидтай “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г гарын үсгээр баталгаажуулан гаргуулан авсан.<br>Мөн байгууллагын мэдээллийн 3 самбар болон байгууллагын цахим хуудас болон ERP систем дээр Авлига болон авлигын эрсдэлээс ангид байлгах зорилгоор шторк, зурагт хуудас болон контент, цахим брошур зэргийг өөрийн байгууллагын боломждоо тулгуурлан олон нийтэд түгээж ажилласан болно. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  Нийслэлийн Цахим хөгжил, Мэдээллийн технологийн газар<br>5хоног<br>Хараагүй Сонсоогүй Хэлгүй юм шиг явсаар л байх уу?<br>АВЛИГЫГ МЭДЭЭЛЬЕ<br>"МЭДЬЕ, НЭГДЭЕ" АЯН<br>Хараагүй Сонсоогүй Хэлгүй<br>110 ТӨЛБӨРГҮЙ<br>АВЛИГЫГ МЭДЭЭЛЬ<br>Танаас гадна өөр 8 хүн<br>Нэг сэтгэгд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  | |
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтад 5 албан хаагчийг хамруулах ажлыг зохион байгуулсан. Мөн байгууллагын нийт 21 ажилтан, албан хаагчдыг Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдөр “Хариуцлагын гэрээ”-г байгуулж, “Ёс зүйн мэдэгдэл”-ийг гаргуулан, баталгаажуулан авч, зохион байгуулалтын арга хэмжээг байгууллагадаа авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | 10.000,0 | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй бүхий л арга хэмжээг дэмжин авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас өгсөн уриалга, зөвлөмж, аяны талаарх мэдээ мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны 1,200 байгууллагын 29,000 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаагаа цахимаар явуулдаг Дотоод удирдлагын UBERP систем болон байгууллагын цахим хуудас https://it.ulaanbaatar.mn/, байгууллагын facebook хуудсаараа дамжуулан иргэд олон нийтэд нээлттэй байршуулах ажлыг зохион байгуулсан.<br>“Мэдье, нэгдье” аяны хүрээнд байгууллагын хэмжээнд Авлигаас урьдчилан сэргийлэх хүрээнд ажлын үр нөлөөг дээшлүүлэх, албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан 1 сарын хугацаатай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аянд манай байгууллага хамт олноороо амжилттай оролцож, нийслэлийн 90 гаруй байгууллагаас 5 дугаар байранд шалгарч, “Батламж”, мөнгөн шагналаар шагнагдаад байна.  | |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх | Жилдээ | - | Тайлант хугацаа буюу 2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагаас нийт 37 гэрээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллахаар байгуулсан бөгөөд гэрээний зүйл, заалтад “Захиалагч, Гүйцэтгэгч талууд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, холбогдох хууль, дүрэм журмыг чандлан баримтална” гэх заалтыг байгуулагдаж байгаа гэрээ бүр дээрээ шинээр оруулан ажиллаж байна. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | | |
| | | 3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх<br>Сургалт, мэдээлэл авсан байх<br>Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | Жилдээ | - | Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах зорилгоор байгууллагын цахим сайтад 1 сарын туршид 14 удаа АТГ-аас гаргасан шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргийг байршуулж нийт давхацсан тоогоор 196 үзэлт, хандалтыг аваад байна.<br>Мөн байгууллагын нийт 21 ажилтан, албан хаагчдыг Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдөр “Хариуцлагын гэрээ”-г байгуулж, “Ёс зүйн мэдэгдэл”-ийг гаргуулан, баталгаажуулан авч, зохион байгуулалтын арга хэмжээг байгууллагадаа авч хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр АТГ-ын Сургалт, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар М.Жамъянчойжилыг байгууллага дээрээ авчирч, 1 цагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  | |
| **ШИЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ) | Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлох ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх Тайланд нотломжийг хавсаргасан байх | 2 дугаар улирал | 20.000,0 | Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд иргэн аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлдэггүй бөгөөд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахимжуулах хүрээнд "Онлайн бизнес төв"-ийн "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-д 2023 онд Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны 29, Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2, нийслэлийн Онцгой байдлын газар 2, 9 дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн 9 үйлчилгээ буюу нийт 42 үйлчилгээг цахимжуулсан. Нийслэлээс олгодог зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагаа эрхлэх 134 нэр төрлийн үйлчилгээг цахимжуулснаас хамгийн их эрэлттэй байдаг 86 үйлчилгээг төрийн үйлчилгээний операторын нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд https://e-business.mn/ системд нэгтгэсэн. Нийслэлийн нутгийн захиргааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудаас олгодог үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг "Онлайн бизнес төв" системийг ашиглан иргэн, аж ахуй нэгжид үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгоод байна. Иргэн аж ахуй нэгж байгууллагууд 2 эх үүсвэрээр үйлчилгээний хүсэлтийг авч шийдвэрлэлтийг хүргэж байна. | |
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх<br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх<br>Арга хэмжээнд удирдлагын Тайланд нотломжийг хавсаргасан байх. | 1 дүгээр улирал | - | Байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд НЗДТГ-т тайлагнаж, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр байгууллагын тайлангийн хурал дээр танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.<br>Мөн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулагдсан "Мэдье, нэгдье" аянд байгууллагаараа нэгдэж, газрын даргаар 2023.10.06 өдөр төлөвлөгөө гаргуулан батлуулж, 1 сарын хугацаанд төлөвлөгөөний дагуу зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажилласан бөгөөд нийслэлийн хэмжээний байгууллагуудаас 5 дугаар байранд шалгарч “Батламж”, мөнгөн шагналаар шагнагдаад байна. | |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд санал, зөвлөмжийг тусгасан байх | Санал тусгасан байх<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | - | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдсантай холбоотой “Байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулалтын шатанд явж байгаа бөгөөд Авлигатай тэмцэх газраас өгсөн санал зөвлөмжийг тусган ажиллаж байгаа болно.<br>Мөн хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын нийт 21 албан хаагчдаас 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдөр “Хариуцлагын гэрээ”-г байгуулж, “Ёс зүйн мэдэгдэл”-ийг гаргуулан, баталгаажуулан авч, зохион байгуулалтын арга хэмжээг байгууллагадаа авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Албан хаагчдаар гарын үсэг зуруулсан байдал. | |
| | | 5.3 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Дүгнэлт зөвлөмж гаргасан байх | 4 дүгээр улирал | - | Бодлогын болон захирамжлалын баримт бичгүүд бусад төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээний 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг газрын даргаар 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу бодлогын баримт бичиг /Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө/-ийн хэрэгжилтэд явцын болон эцсийн гэсэн 2 хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж | 100% |

НЗДМТГ-ын даргын 2023 оны А/75 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ"-г байгуулсан албан хаагчдын жагсаалт

2023.10.09

| № | Овог, нэр | Албан тушаал | Гарын үсэг | Огноо |
|---|---|---|---|---|
| | нэг. Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс | | | |
| 1 | Д.Сайнхүү | Хэлтсийн дарга | | |
| 2 | Г.Энхзул | Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн | | |
| 3 | Б.Оюунбайгаль | [illegible] | | |
| 4 | Т.Отгонжаргал | [illegible] | | |
| 5 | Б.Энхтуяа | Хууль, эрх зүй, гэрээ хариуцсан ажилтан | | |
| 6 | Г.Цогтбаяр | Архив, бичиг хэргийн эрхлэгч | | |
| | хоёр. Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтэс | | | |
| 7 | Б.Чойжилсүрэн | Хэлтсийн дарга | | |
| 8 | Е.Тунгалаг | Системийн төлөвлөлт, технологийн шийдэл хариуцсан ахлах мэргэжилтэн | | |
| 9 | Ц.Оюунсүрэн | Системийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 10 | Ж.Хонгорзул | Системийн мэргэжилтэн | | |
| 11 | [illegible] | Орон зайн мэдээллийн систем, дата анализ хариуцсан ажилтан | | |
| 12 | Ө.Ариунжаргал | Системийн зохицуулагч | | |
| 13 | Д.Пүрэвдорж | Системийн [illegible] | | |
| | гурав. Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтэс | | | |
| 14 | Н.Пүрэв | Мэдээллийн аюулгүй байдал [illegible] хариуцсан ахлах мэргэжилтэн | | |
| 15 | [illegible] | Мэдээллийн сервер, өгөгдлийн сангийн аюулгүй байдал хариуцсан инженер | | |
| 16 | [illegible] | Сүлжээний мониторинг, удирдлагын инженер | | |
| 17 | А.Оюун-Эрдэнэ | Хяналт удирдлагын системийн инженер | | |
| 18 | [illegible] | Дэд бүтцийн [illegible] инженер | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлэгдсэн. | |
| | | 5.4 Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах | Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх. | Жилдээ | - | Байгууллагын хэмжээнд 2023 оны 12 дугээр сарын 12-ны өдрийн байдлаар нийт 49 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс эх үүсвэрээр нь ангилбал Засгийн газрын 11-11 төвийн дугаараас 28, eservice.mn системээр 4, 1800-1200 тусгай дугаараас 9, НҮНТ-өөр 2, онлайн бизнес төв системээр 1, хэсгийн ахлагчийн системээр 3 өргөдөл, гомдол, хүсэлтийг 6 эх үүсвэрээс хүлээн авч шийдвэрлэж ажилласан. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт өргөдөл гомдлоос дийлэнх нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэглээнд нэвтрүүлсэн нийслэлийн цахим үйлчилгээний eservice.ulaanbaatar.mn системийн өргөдөл гомдол гаргах цэс нь ажиллахгүй, Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний www.Smartcar.mn системийн ажиллагаа болон авто тээврийн хэрэгслийн татвар төлөлттэй холбоотой, Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ /RFID чип/ суурилуулахыг эсэргүүцсэн гомдлууд зонхилж байна. | 100% |
| | | 5.5 Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах | Ажлын хэсэг болон албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилт үр | Жилдээ | - | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А, хүний нөөцтэй холбоотой Б тушаалуудын төслийг боловсруулахдаа Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны шийдвэрийн хяналтын дагалдах хуудсаар хэлтсийн дарга болон хууль эрх зүйн асуудал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дүнг тооцсон байх Тушаал шийдвэрийн үндэслэлийг хуулийн дагуу боловсруулсан байх | | | хариуцсан мэргэжилтнээс санал авч газрын даргаар батлуулж газрын нэгдсэн хурал дээр танилцуулж ажилладаг. 2023 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцтэй холбоотой Б-63, үйл ажиллагаатай холбоотой А-105 тушаалыг батлуулж ажилласан. Мөн газрын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн ажлын үр дүнг илтгэх хуудсаар тухай бүр нь танилцуулж байна. | |
| | | 5.6 Худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр А3 сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх | 55 албан хаагчийг хамруулсан байх | Жилдээ | - | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн чиглэлийн хүрээнд 2023 онд Худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээтэй сургалтад 3 албан хаагч хувийн зардлаараа хамрагдаж, гэрчилгээ авснаар байгууллагын хэмжээнд худалдан авах ажиллагааны А3 сертификаттай 5 албан хаагч болж нэмэгдүүлсэн. Шинээр 3 албан хаагч А3 гэрчилгээтэй сургалтад хамрагдахаар холбогдох байгууллага руу хүсэлтээ илгээгээд байна. | 100% |
| | | 5.7 Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулсан байх Төрийн хэмнэлтийн тухай болон | Жилдээ | - | Байгууллагын 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулж, 1 удаагийн тэтгэмж урамшуулал болон байгууллагынхаа хэмжээнд 1 принтер ажиллуулж бичгийн цаас, принтерийн хор гэх мэт өдөр тутам хэрэглэгдэх бичиг хэргийн зардлуудаа танаж, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг сар, улирлаар нэгтгэн тухай бүрт нь тайлагнаж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төсвийн тухай хуулиудыг хэрэгжилтийг хангасан байх | | | | |
| | | 5.8 Нийслэл, дүүргийн төрийн албан хаагч нарт ёс зүйн сургалт зохион байгуулах | Төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулж, албан хаагч нарыг хамруулсан байх. | Жилдээ | 20.000,0 | Тус газрын даргын 2023 оны А/74 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль шинээр батлагдсантай холбоотой байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалган тогтоох, төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга хариуцлагын чиглэлээр сургалт зохион явуулах үүрэг бүхий "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Мөн нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн гарын авлагыг хэлтэс нэгжүүдийн дарга нарт тарааж өгсөн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын 21 албан хаагчидтай "Хариуцлагын гэрээ" байгуулж, "Ёс зүйн мэдэгдэл"-ийг баталгаажуулж авсан. НЗДТГ-ын нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвд байгууллагын 16 албан хаагчийг Ёс зүйн сургалтад хамруулахаар захиалга өгсөн.<br>Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр АТГ-ын Сургалт, соён | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэгээрүүлэх хэлтсийн комиссар М.Жамъянчойжилыг байгууллага дээрээ авчирч, 1 цагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно. | |
| 6 | | 5.9 Нийслэлийн өмчит компаниудыг олон нийтийн хяналттай, нээлттэй компани болгох, ур чадвар бүхий менежментийн багийг ажиллуулах | Олон нийтийн хяналтын нэмэгдүүлсэн байх | Жилдээ | - | Хамааралгүй | - |
| | | 5.10 Ёс зүйтэй, шударга өрсөлдөх орчныг бүрдүүлж, цэвэр, тунгалаг бизнесийг дэмжин хөгжүүлэх | Шинэчилсэн журам, захирамжийн тоо | Жилдээ | - | Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл гомдол, санал, хүсэлтийг **6** эх үүсвэрээс хүлээн авдаг бөгөөд 2023 он гарснаас хойш нийт **49** өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс Засгийн газрын 11-11 төвийн дугаараас **22**, eservice.mn системээр **4**, 1800-1200 тусгай дугаараас **9**, НҮНТ-өөр **1**, smartcar системээр **9**, онлайн бизнес төв системээр **1**, хүний нөөцтэй холбоотой **11** өргөдөл, санал, хүсэлт ирсэн байна. Өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах эх үүсврийг нэмэгдүүлэх хүрээнд байгууллагын и-мэйл support@ulaanbaatar.mn болон дижитал UB гар утасны аппликейшнаар гаргах боломжийг бүрдүүлсэн. Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 7 цаг байсан бөгөөд "Мэдье, нэгдье" аяны хүрээнд хугацааг 9 хоног 11 цаг 53 минут болж буурсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ШУУР АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 7 | | 5.11 Нийтийн албанд танилын хүрээгээр томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх | Төрийн албаны тухай хууль, журмын хэрэгжилтийг хангасан байх | Жилдээ | - | Төрийн албаны тухай хуулийн хүрээнд Төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй албан хаагчдаас сонгон шалгаруулж ажил томилох зарчмыг баримтлан ажиллаж байна. 2023 оны байдлаар шуур ажиллагааны хүрээнд зөрчилтэй томилгоо байхгүй болно. | 100% |
| | | 5.12 Авлига, албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх, холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэх | Холбогдох хууль журмыг зөрчин томилогдсон албан хаагчдыг чөлөөлөх | 1, 2 дугаар улирал | - | Байгууллагын хэмжээнд зөрчилтэй томилгоо байхгүй болно. Байгууллагад сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан дагуу хууль, тогтоомжийг дагаж мөрдөн сул орон тоог нөхөн ажиллаж байна. | 100% |
| **Дундаж оноо:** | | | | | | | **98.42%** |

**ТАЙЛАН ХЯНАСАН:**
ЦАХИМ ШИЛЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.НАМХАЙРИНЧЭН

**ТАЙЛАН НЭГТГЭН ГАРГАСАН:**
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЗУЛ

ЭБАТ Б.ОРХОНБАЙГАЛЬ